


ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2015-07 САР)

Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2015 оны 7 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 4857 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС


2015 оны 7 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 1.5%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 10.2%-иар тус тус буурчээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ орон сууцны үнэ бага зэрэг буурсан, мөн хуучин орон сууцны үнийн уналт эрчимтэй үргэлжилсэн хэвээр байгаа зэрэг нь орон сууцны дундаж үнэ сүүлийн хоёр сард огцом буурахад нөлөөлжээ.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд энэ сарын орон сууцны үнийн бууралт нь 2015 оны эхний 7 сарын хамгийн доод түвшиндээ буюу -10.2 хувьд хүрчээ.

Жишээ: БГД-ийн “Korea town” цогцолборт 2014 оны 7 дугаар сард 1 м² дундаж үнэ 2,248,000 төгрөг байсан бол 2015 оны 6 дугаар сарын байдлаар 2,040,000 төгрөг болж 9.2%-иар буурсан байна.


1. Шинэ орон сууцны үнэ¹

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 7 дугаар сарын байдлаар 2,143,000 төгрөг болж өмнөх сараас 0.3%, өнгөрсөн оны мөн үеэс 4.4%-иар буурсан байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2015.07/


Орон сууцны дундаж үнэ	2,143,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-4.4%
Сарын өсөлтийн хувь	-0.3%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр²

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ³ нь 2015 оны 7 дугаар сарын байдлаар 90,838,000 төгрөг болж өмнөх сараас 1.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 10.2 хувиар тус тус буурсан байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2015.06/


Орон сууцны дундаж үнэ	90,838,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-10.2%
Сарын өсөлтийн хувь	-1.2%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сар.төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

² Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

³ 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)

¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.